



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/814

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журмыг нэгдүгээр, Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай үйлчлүүлэгчийг эрэмбэлэх журмыг хоёрдугаар, Эмнэлгийн яаралтай тусламжийн эрэмбэлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, сувилал, сэргээн засах төв, сувилахуйн төв, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, захирал нарт тус тус даалгасугай.

3. Мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



С. ЭНХБОЛД

141220123

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
16 сарын 30-ны өдрийн 174 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн байгууллагын яаралтай тусламж үзүүлэх, зохион байгуулахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эмнэлгийн яаралтай тусламж (цаашид яаралтай тусламж гэх) гэж хүний амь насанд аюултай цочмог өвчин, осол гэмтлийн үеийн тусламж, эмгэгийн оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэх зорилгоор хойшлуулшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээг хэлнэ.

1.3. Яаралтай тусламжийг "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллагууд үзүүлнэ.

1.4. Эмнэлгийн болон төрөх үеийн яаралтай тусламжийг тухайн иргэнд ойр байгаа эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.

1.5. "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллагууд бүтэц, үйл ажиллагааны стандарт, тусламж, үйлчилгээний төрөл, чиглэл, үйлчлэх хүрээний хүн амын тоонд үндэслэн, энэхүү журам болон бусад холбогдох хууль эрх зүй, байгууллагын өвөрмөц тусламж үйлчилгээ болон орчин, нөхцөлд нийцүүлэн яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах журам баталж, мөрдүүлнэ.

Хоёр. Яаралтай тусламж үзүүлэхэд баримтлах нийтлэг зарчим

2.1. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд амь насанд нь учирч буй эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчээс эхэлж үзүүлэх эрэмбэлэлтийн зарчим баримтална.

2.2. Амь нас нь эрсдэх магадлал өндөртэй байгаа үйлчлүүлэгчийг эмнэлгийн байгууллага тосч үйлчлэх нийтлэг зарчим байна.

2.3. Яаралтай тусламжийг хүнлэг, энэрэнгүй, шашин шүтлэг, үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, үүслээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид, үйлчлүүлэгч түүний гэр бүлд ээлтэй, нээлттэй, хүний эрх, аюулгүй байдлыг дээдэлсэн хувийн нууцыг нь хадгалах зарчимтай байна.

2.4. Үйлчилгээ үзүүлэгч нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм, хэмжээг баримтална.

2.5. Яаралтай тусламж үйлчилгээ нь шуурхай, тоног төхөөрөмж, хүн хүч, машин, техник, хэрэгслийн 24 цагийн бэлэн байдлын зарчимтай байна.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Яаралтай тусламжийн тасаг, нэгжийн эрхлэгч/дарга нар нь тасгийн үйл ажиллагаа, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай байна.

3.2. Яаралтай тусламжийн тасаг нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий, эмнэлгийн яаралтай тусламжаар мэргэшсэн эмч, сувилагчтай

байх ба тусламж, үйлчилгээний шатлал, төрөл, онцлогоос хамааран шаардлагатай бол бусад төрөлжсөн мэргэшлийн /мэс засал, дүрс оношлогооны, эх барих, хүүхэд,/ эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй байж болно.

3.3. Тасгийн бүх мэргэжилтэн, ажилтнуудын үүрэг, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, дүрэмд тусган, баталгаажуулж, хэрэгжүүлж ажиллана.

3.4. Халдварт өвчний дэгдэлт, олныг хамарсан гамшиг, осол нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, бэлэн байдлын төлөвлөгөө, яаралтай үед дуудагдаж ажиллах мэргэжлийн багийг томилгоожуулсан байна.

3.5. Тасгийн бүх ажилтнууд амилуулах суурь тусламжийн сургалтад хамрагдсан, шаардлагатай үед тусламжийг бие даан үзүүлэх, бусдад сургах чадвартай байна.

3.6. Яаралтай тусламжийн тасаг нь түргэн тусламжийн дуудлага хүлээн авах, зохицуулах үүрэг бүхий мэргэжилтний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй байна.

3.7. Улсын хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангаж байгаа эмнэлэг тухайн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, стандартыг боловсруулж, Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан арга хэмжээг авч, хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.8. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв эмнэлгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Яаралтай тусламж, үйлчилгээний тасгийн үйл ажиллагаа

4.1. Яаралтай тусламжийг аюулгүй, нотолгоонд суурилсан, эмчилгээний хамгийн сүүлийн үеийн шинэлэг арга, технологи баримтлан үзүүлнэ.

4.2. Яаралтай тусламжийн эмч, сувилагч үйлчлүүлэгчийг угтан авч, бүртгэл, яаралтай тусламжийн хуудаст бүртгэн, анхны үзлэгээр амин үзүүлэлт, эмгэг шинжүүдийг тодорхойлон, эрэмбэлж, шаардагдах тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулна.

4.3. Анхан шатны бүртгэл, хяналтын хуудсыг 2 хувь үйлдэж, үндсэн хувийг эмнэлгийн баримтад, 2 дахь хувийг үйлчлүүлэгчийг өөр эмнэлэг, тасагт шилжүүлсэн буюу гэрт нь буцаасан тохиолдолд хамт хүргүүлнэ.

4.4. Үйлчлүүлэгчийн амь тэнссэн байдал, амин үзүүлэлт тогтворжсоны дараа холбогдох тасагт болон өөр эмнэлэг, гэрт нь, өрхийн эмчийн хяналтад шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4.5. Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь гадны нөлөөтэй үүсгэгдсэн "гэмт хэргийн шинжтэй" бол цагдаагийн байгууллагад анх хүлээн авсан эмч нь мэдээлнэ.

4.6. Үйлчлүүлэгчийн нэр хаяг нь тодорхойгүй, өөрөө мэдүүлэг өгөх боломжгүй, амин үзүүлэлтүүдийн алдагдалтай, зүрх зогссон байдалтай эмнэлэгт ирээд нас барсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлж, холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

4.7. Амилуулах тусламж шаардлагатай үйлчлүүлэгчид шууд амилуулах лавшруулсан тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд эрчимт эмчилгээний тасагт шилжүүлэн хэвтүүлнэ.

4.8. Яаралтай тусламжийн тасагт нас барсан тохиолдолд яаралтай тусламжийн хуудсаар эмгэг судлалын шинжилгээнд орно.

4.9. Үйлчлүүлэгчийн өвчний оношийг богино хугацаанд тогтоох боломжгүй нөхцөлд хяналт, эмчилгээний хэсэгт шилжүүлж, холбогдох шинжилгээг шуурхай хийж, эмчлэгч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр асуудлыг шийдвэрлэнэ.

4.10. Ажлын цагаар төрөлжсөн мэргэшлийн эмч, зөвлөх эмч, эмч нарын багийг, ажлын бус цагаар жижүүр эмч дуудаж зөвлөгөө авах болон хамтарсан зөвлөгөөн хийж шийдвэрлэнэ.

4.11. Халдварт өвчний сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөнд авч, халдварын сэргийлэлт, хяналт, шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед ажиллах журам болон бусад холбогдох журмыг баримталж ажиллана.

4.12. Эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн үйлчилгээний багаас мэдээлэл хүлээн авч амилуулах суурь болон амилуулах лавшруулсан тусламжийн зөвлөгөө, мэдээлэл өгч, тосч үйлчлэх бэлэн байдлыг хангаж ажиллана.

4.13. Үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд ажлын цагаар тасгийн эрхлэгчид танилцуулж эмнэлзүй эрхэлсэн дэд захирлаар, ажлын бус болон амралтын өдрүүдэд жижүүрийн ахлах эмчээр баталгаажуулж эмгэг анатомийн задлан шинжилгээнд яаралтай тусламжийн хуудаст тэмдэглэн оруулна.

4.14. Үйлчлүүлэгчийг хүлээж авснаас эхлэн гэрт нь гаргах буюу шилжүүлэх хүртэлх тусламж, үйлчилгээний үйл явцыг үйлчлүүлэгч, түүний ар гэрт шуурхай, ил тод ойлгомжтой мэдээлж, байнгын холбоотой ажиллана.

4.15. Эрүүл мэндийн байгууллага нь холбогдох эмнэлзүйн заавар, удирдамжид заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх, шилжүүлэх, гаргах шалгуурыг баримталж ажиллана.

4.16. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн яаралтай тусламжид хүлээн авсан нийт үйлчлүүлэгч, зөвлөгөө өгч буцаасан болон өөр эмнэлэгт шилжүүлсэн үйлчлүүлэгч, тусламж, үйлчилгээ үзүүлэн гаргасан үйлчлүүлэгчийн цахим бүртгэл, мэдээллийн сантай байна.

Тав. Өрхийн эрүүл мэндийн төв болон зөвхөн амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлдэг клиникийн яаралтай тусламж үйлчилгээ

5.1. Өрхийн эрүүл мэндийн төв нь яаралтай, амь нас нь тэнссэн, зайлшгүй шаардлагаар хандсан үйлчлүүлэгчийг харьяалал харгалзахгүй хүлээн авч, эрэмбэлэн, эмнэлгийн анхны болон амилуулах суурь тусламж үзүүлнэ.

5.2. Үйлчлүүлэгчийн амь нас тэнссэн байдалд, амин үзүүлэлтийг тогтворжуулах арга хэмжээг шуурхай авч, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүргэх, боломжгүй нөхцөлд түргэн тусламж дуудан холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

5.3. Зайлшгүй шаардлагаар төрөлжсөн мэргэшлийн эмч дуудаж тусламж, үйлчилгээг хамтран үзүүлэх арга хэмжээг авна.

5.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд төгсөлтийн дараах жил бүрийн багц цагийн сургалтын нэг кредит нь эмнэлгийн яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан байна.

5.5. Өрхийн эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг журамлан

тусгаж, хэрэгжүүлж ажиллана.

5.6. Харьяа, үйлчлэх хүрээний хүн амд яаралтай тусламж үзүүлэх тээврийн хэрэгсэл, эм, тариа багаж, хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг холбогдох журам, стандартад нийцүүлэн хангаж ажиллана.

5.7. Харьяа хүн амд олныг хамарсан болзошгүй халдварт өвчин, осол гэмтэл, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөтэй, хүч хэрэгслийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, жил бүр тодотгол хийж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
12 сарын 30 ны өдрийн 414 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ШААРДЛАГАТАЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЭРЭМБЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Энэхүү журам нь үйлчлүүлэгчийн амин үзүүлэлт, эмнэлзүйн шинж тэмдгийг үндэслэн нэн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай эрэмбийг тогтоох, үр дүнтэй, оновчтой тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилготой.

Хоёр. Тодорхойлолт

2.1. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгчийн амь насанд учирч буй эрсдэлээс хамаарч "цаг хугацааны чухал"-ын зэрэглэлээр тусламж үзүүлэх дарааллыг яаравчлан эрэмбэлэх зарчмыг хэлнэ.

Гурав. Эрэмбэлэх үйл ажиллагааны нийтлэг зарчим

3.1. Яаралтай тусламжийн эрэмбэлэл нь өвчнийг оношлох бус үйлчлүүлэгчийн эмнэлзүйн байдлыг үнэлэх зарчимд тулгуурлана.

3.2. Гэнэтийн өвчин, осол гэмтэл, хордлогод өртсөн, амь нас нь тэнссэн үйлчлүүлэгчид яаралтай тусламжийг нэн түрүүнд үзүүлэх зарчмыг баримталж ажиллана.

3.3. Эрэмбэх үйл ажиллагааг үйлчлүүлэгчийг хүлээж авснаас хойш 5 минутын дотор хийж гүйцэтгэнэ.

3.4. Тухайн эрэмбэд тохирсон өнгийн тууз эсвэл зохих таних тэмдгийг үйлчлүүлэгчийн нүдэнд ил үзэгдэх хэсэг, гарын шуу, хүзүү болон шархдаж, гэмтээгүй хэсэгт зүүж тэмдэглэнэ.

3.5. Эрэмбэлсэн тухай мэдээллийг яаралтай тусламжийн хуудас эсвэл цахим яаралтай тусламжийн хуудсанд тэмдэглэнэ.

3.6. Үйлчлүүлэгчийн эрэмбийн дарааллаар эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг эмч эсвэл эрэмбэ хариуцсан сувилагч үзүүлнэ.

3.7. Эмч үзлэгийн үед үйлчлүүлэгчийг давтан эрэмбэлж, зөв эсэхэд хяналт тавих ба эрэмбийн зэрэглэлийг өөрчилж болно.

3.8. Эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг нэгжийн бүртгэл, мэдээллийн хэсэгт "Эмнэлгийн яаралтай тусламжийн эрэмбэлэлтийн хүснэгт"-ийг эмч сувилагч, үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд ил харагдахуйц газар байрлуулсан байна.

3.9. Эрэмбэ бүрт заасан хугацаа нь яаралтай тусламж эхлүүлэх, хүлээгдэж болох дээд хязгаар байх бөгөөд тусламж, үзүүлж зүгшрүүлэн тогтворжуулах хугацаа биш болохыг хатуу баримтална.

3.10. Яаралтай тусламжийн тасаг, нэгжид үйлчлүүлэгч олноор зэрэг ирсэн тохиолдолд эрэмбэлэлтийг цаг хугацаа, нөөц бололцоог зохистой зөв хуваарилах, байдлаар хийнэ.

**Дөрөв. Яаралтай тусламж шаардлагатай насанд хүрсэн
үйлчлүүлэгчийн эрэмбэлэлт**

4.1. Яаралтай тусламжийн тасаг, нэгжид ирсэн үйлчлүүлэгчийг эрэмбэлэлт хариуцсан мэргэжилтэн (сувилагч) хүлээн авч амь тэнссэн, амин үзүүлэлт, биеийн байдал болон эмнэлзүйн шинж тэмдгийг үндэслэн дараах 5 зэрэглэлээр эрэмбэлнэ. Үүнд:

Эрэмбэ	Зэрэглэл	Тэмдэглэх өнгө
Эрэмбэ-I	Амь тэнссэн	Хөх
Эрэмбэ-II	Нэн яаралтай	Улаан
Эрэмбэ-III	Яаралтай	Шар
Эрэмбэ-IV	Яаралтай бус	Ногоон
Эрэмбэ-V	Хүлээгдэх боломжтой	Цагаан

4.2. Эрэмбэ-I. Амь тэнссэн үйлчлүүлэгч:

4.2.1. Эрэмбийн хэрэглээ: Амь насанд аюул учирч, амин чухал эрхтний үйл ажиллагаа зогсох, аюул шууд заналхийлж эхэлсэн эмгэгүүд орох бөгөөд нэн яаралтай эмнэлгийн тусламжийг цаг хугацаа алдалгүй үзүүлж эхлэх заалттай. Дээрх тохиолдолд маш богино хугацаанд эмнэлзүйн байдал мууддаг тул лавшруулсан үнэлгээ хийхгүйгээр тусламжийг шууд үзүүлж эхэлнэ.

4.2.2. Энэ үйлчлүүлэгчийг **ХӨХ** өнгөөр эрэмбэлэн тэмдэглэнэ.

4.2.3. Үйлчлүүлэгчийн ирэх үеийн илрэл, харагдах байдал (мэдрэмжийн үнэлгээ)-д дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

4.2.3.1. Зүрх зогсох

4.2.3.2. Амьсгал зогсох

4.2.4. Хүчилтөрөгчийн өлсгөлөнгийн улмаас амин эрхтнүүдийн үйл зогссон (жишээ нь: багтрааны амь тэнссэн байдал, таталтын улмаас амьсгал зогссон байдал)

4.2.5. Хавсарсан томоохон гэмтлүүд (Жишээ нь: Амин эрхтэн бүхий биеийн хэсэг тасарсан, хөвчин бие хуваагдсан, том судас тасарсан байдал, нэн хүнд хэлбэрийн шоктой)

4.2.6. Нэн хүнд хэлбэрийн амьсгалын дутагдал (Жишээ нь: амьсгалын дээд замын бөглөрөл, хураах амьсгал илрэх)

4.2.7. Гүн комын байдал (Жишээ нь: тархины үхлийн эмнэлзүйн шинж илэрсэн)

4.2.8. **ХӨХ** эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна.

- Гэмтлийн шалтгаант гиповолемийн нэн хүнд хэлбэрийн шок /R57.1/
- Пневмоторакс- гэмтлийн гаралтай шахалдалт /S27.0/
- Амьсгалын замын түлэгдэл /T27.0-T27.7/
- Амьсгалын зам бүрэн бөглөрсөн (Ж.нь: хавагнасан, хахсан)
- Хүнд зэргийн түлэгдэл-нийт биеийн гадаргуугийн 30%-с дээш түлэгдсэн /T21-T25/
- Хэвлийн гол судасны цүлхэн хагарсны улмаас үүссэн шок /I25/
- Зүрхний цочмог шигдээсийн хүндрэл- зүрхний архаг дутагдал болон артерийн даралт буурах /I21-I23/
- Хөшүүн багтраа /J46/
- Тархины хүнд гэмтэл глазго комын үнэлгээ 3-9 ухаангүй/S02-05 S06-09/
- Архи согтууруулах ундаа болон хийн хордлогууд /T51, T59/

- Таталтын байдал /G41/
- Амьсгалын гачаалт хам шинж, ЕССМО аппарат заалттай /j00/
- Амин эрхтэн бүхий биеийн хэсэг тасарсан, хөвчин бие хуваагдсан, том судас тасарсан
- Осголт /Т69.1/

4.3. Эрэмбэ-II. Нэн яаралтай үйлчлүүлэгч

4.3.1. Эрэмбийн хэрэглээ: Амин чухал эрхтний үйл ажиллагаа гүнзгий хямарсан, нэн яаралтай тусламж үзүүлэхгүй бол амьсгал, зүрх зогсоход хүрэх хүнд байдлууд хамаарна. Энэ эрэмбийн үйлчлүүлэгч нь амь нас эрсдэх өндөр магадлалтай тул нэн түрүүнд эрэмбэлж, эмч 15 минутын дотор эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлнэ.

4.3.2. Энэ үйлчлүүлэгчийг **УЛААН** өнгөөр эрэмбэлэн тэмдэглэнэ.

4.3.3. Үйлчлүүлэгчийн гаднах харагдах байдал (мэдрэмжийн үнэлгээ)-д дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

- Даралт ихсэлт (Систолын даралт 220, диастолын даралт 130 мм.м.у.б, даралт ихсэлтийн шинж тэмдэгтэй)
- Гавал тархины (цаашдын урхаг ихтэй, ухамсарт ухааны өөрчлөлттэй)
- Хүнд хавсарсан гэмтэл
- Ухамсарт ухааны өөрчлөлтүүд (хөөрөл, догшролын байдал)
- Ухаан санааны байдлын өөрчлөлт (Глазго комын үнэлгээ 9-с доош)
- Нүдний салст химийн бодисоор түлэгдэх
- Харшлын хүнд зэргийн урвал (Анафилакси-Гаждал)
- Арьс хуулрах, ховхрох, үрчийх, салст шархалж гэмтэх
- Амьсгаадах (Хүнд зэргийн амьсгалын гачаалт байдал (Амьсгал давчдал)
- Зүрхний шалтгаант цээжний өвдөлт
- Зүрхний бус шалтгаант цээжний өвдөлт (Цээжний өвдөлт нь дарж, базаж, урагдаж байгаа мэт юм шиг)
- Эмийн тун хэтрэлт (ухамсарт ухаан алдагдаагүй, донтолт)
- Хэвлийн гялтан цочирлын шинжтэй, хүчтэй өвдөлт илрэх (Жишээ нь: Шугаман үнэлгээгээр 8-10 оноо
- Мэдрэлийн гаралтай нурууны өвдөлт (Гэмтлийн бус) Шугаман үнэлгээгээр 8-10 оноо
- Хоол боловсруулах замын цус алдалт (Амин үйл алдагдсан)
- Тархины судасны хүнд эмгэгүүд (Мэдрэлийн үйл ажиллагааны гүнзгий алдагдалтай)
- Үгдэрсэн багтраа (PEFR < 40%)
- Үтрээний цочмог цус алдалт (Амин үйлийн алдагдалтай, өвдөлтийн шугаман үнэлгээгээр 5 оноо)
- Бөөлжилт, суулгалт (Хүнд зэргийн усгүйжилтын байдал)
- Ноцтой халдварын хүндрэлийн ноцтой шинжүүд илэрсэн (Ж.нь: Цэгчилсэн тууралт, хордлого)

- Үжлийн халууралт (Биеийн хэм $>38^{\circ}\text{C}$, үжлийн эмнэлзүйн бусад шинжүүд илэрсэн)
- Нийгэмдээ, орчиндоо болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэц, хөдөлгөөний догширолын байдал (хий үзэгдэл-дэмийрлийн, эмгэг төрхийн,
- Бухимдлын, оюуны хомсдлын, epileпсийн, сэтгэл түгшилтийн, сэтгэл хөөрлийн, сэтгэл гутралын болон амиа хорлох бодол санаа, хүүхдэрхэх, кататоник)
- Сэтгэц, хөдөлгөөний хурц өөрчлөлт бүхий ухамсарт ухааны өвөрмөц алдагдал (ухамсарт ухаан бүрийтэн, будангуйран, дэмийрэн, зүүдчилэн, нойрмоглох балартах байдал)
- Сэтгэц, хөдөлгөөний хурц өөрчлөлт бүхий солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, хий үзэгдэл дэмийрлийн хам шинж, паранойд, кататоник, Кандинский Клеромбогийн хам шинж)
- Сэтгэцийн өвчний цочмог илрэл болон сэдрэл (Ухаангүй болон догшролын байдал, өөртөө болон ойр тойрондоо заналхийлсэн)
- Чихрийн шижин (гипогликеми болон гипергликемийн ком)
- Толгойн өвдөлт (Гэнэтийн хүчтэй даамжирсан өвдөлт, шугаман үнэлгээгээр 8-10 оноо)
- Бэлгийн хүчирхийлэл

4.3.4. УЛААН эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна.

- Гавал тархины гэмтэлтэй /S02-S05 S06-09/
- Хавсарсан гэмтэл, олон хавирганы хугарал /S22.4/
- Хүзүү болон нуруу нугасны гэмтэл /S05-S05, S22, S32/
- Хүнд зэргийн түлэгдэл нийт биеийн гадаргуугийн 20-29% /T21-25 T31.2/
- Их талбайг хамарсан арьс, салстын бүтцийн өөрчлөлт- нийт биеийн гадаргуугийн 75%-100%, түүнээс дээш хамарсан /R23/
- Лайеллын хам шинж L51.2
- Шүлт болон идэмхий бодисын түлэгдэл /T21-T26/
- Анафилакси /R57.8/
- Зүрхний цочмог шигдээс /I21/, тогтворгүй бах /I20.0/, зүрхний архаг дутагдал /I50/
- Эмийн тун хэтрэлт, тодорхой бус эмийн хордлого /T36/
- Хэвлийн гол судасны цүлхэн /I25/
- Хоол боловсруулах замын цус алдалт/K25/, шокын байдалтай
- Тархины цус харвалтууд /I61-I63/
- Гуурсан хоолойн үгдэрсэн багтраа /J45-J46/
- Уушгины архаг бөглөрөлтөт өвчин/J44/, бачуурах
- Аяндаа зулбах/O03/
- Умайн гадуурх жирэмслэлт, дотуур цус алдалттай/O00/
- Төвөнхийн халхавчийн үрэвсэл/G38.7/
- Менингококкын гарвалт менингит

- Үжил /A40-A41.9/
- Сэтгэц, зан үйлийн эмгэг /F00-F99/
- Сэтгэцийн өвчний цочмог хөдлөл (Ухаангүй болон догшролын байдал, өөртөө болон ойр тойрондоо заналхийлсэн) /F30/
- Гипогликеми /E15-E16/
- Чихрийн шижингийн кетоацидоз /E10/
- Гипергликеми /E10/
- Бөөрний чулууны өвдөлт /N20/
- Нурууны жийргэвчний гэмтэл
- Мэдрэлийн ёзоорын дарагдал
- Нүдний эвэрлэгийн үрэвсэл
- Солонгон бүрхүүлийн үрэвсэл
- Цээж хэвлийн ил шарх /Шокын байдалтай/ /S21, S31/

4.4.Эрэмбэ-III. Яаралтай үйлчлүүлэгч

4.4.1. Эрэмбийн хэрэглээ: Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтүүд хэвийн бус, эмнэлгийн тусламж үзүүлэхгүй бол цаашид энэ байдал нь даамжран дордох магадлалтай гэхдээ яаралтай тусламжийн тасгийн хэт ачааллын үед түр хүлээх боломжтой эмгэгүүд хамаарна. Энэ эрэмбийн үйлчлүүлэгчдэд 30 минутаас хэтрэхгүй хугацаанд эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлнэ.

4.4.2. Энэ үйлчлүүлэгчийг **ШАР** өнгөөр эрэмбэлэн тэмдэглэнэ.

4.4.3. Үйлчлүүлэгчийн гаднах харагдах байдал (мэдрэмжийн үнэлгээ)-д дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

- Даралт ихсэлт (Агшилтын даралт 220, сулралын даралт 130 мм.м.у.б, даралт ихсэлтийн шинж тэмдэггүй)
 - Дунд зэргийн толгойн гэмтэл (Ухаантай, бөөлжилттэй)
 - Хүчирхийлэлд өртсөн, донтолтын байдал-хараа хяналтгүй)
 - Бөөлжилт (Дунд зэргийн усгүйжилттэй)
 - Суулгалт (Эмчилгээний засрахгүй цустай суулгалт)
 - Диализын хүндрэлүүд
 - Арьс улайх, идээлэх, цэврүүтэх, хавагнах, шархлах, хүчтэй загатнаа, цуурах, таталдаж өвдөх шинж тэмдэгтэй
 - Халдварын шинжтэй
 - Гуурсан хоолойн багтрааны хөнгөн болон дунд зэргийн явцтай (PEFR > 40%)
 - Амьсгаадах (Хүндэвтэр зэргийн амьсгалын гачаалт байдал)
 - Зүрхний бус шалтгаант цээжний өвдөлт (Цээжний хөндийн эрхтний шалтгаангүй-мэдрэл булчин, яс, үений гэмтэл)
 - Амин үйл тогтвортой хоол боловсруулах замын цус алдалт
 - Амин үйл тогтвортой үтрээний цочмог цус алдалт
 - Таталт- ухаантай ирсэн
 - Сэтгэцийн хурцавтар өөрчлөлт бүхий солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, хий үзэгдэл дэмийрлийн хам шинж, паранойд, парафренийн хам шинж)
 - Сэтгэцийн хурцавтар өөрчлөлт бүхий сэтгэлийн хөдөлгөөний алдагдал (сандрах дайрлага, сэтгэл түгшилт, сэтгэл хөөрөл, сэтгэл гутралын хам шинж)

– Сэтгэцийн хурцавтар өөрчлөлт бүхий сэтгэц эмгэгийн хам шинжүүд (нойргүйдэл, өвчирхөх, истери, зан үйл, эмгэг төрхийн хам шинж, гэнэтийн эмгэг дур)

- Сэтгэцэд нөлөөт эмийн гаж нөлөөний хам шинж
- Сэтгэцийн өвчний цочмог хөдлөл - амиа хорлох сэдэлтэй
- Хэвлийн өвдөлт (Шугаман үнэлгээгээр 4-7 оноо)
- Толгойн өвдөлт (Шугаман үнэлгээгээр 4-7 оноо)
- Бага зэргийн гэмтэлтэй (Шугаман үнэлгээгээр 8-10 оноо)
- Судас, мэдрэл, шөрмөс булчингийн гэмтэлтэй шархнууд
- Халдварлагдсан шарх

4.4.4. **ШАР** эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна.

- Гавал тархины гэмтэл, Глазго ком үнэлгээ 9-12/ /S02-S05/
- Мөрний урагшаа мултрал /S49/
- Үений мултралууд /S03.0, S43.0, S53, S63.1, S73.0, S83.0, S83.1, S93.1/
- Ясны хугарлууд /S32, S42, S52, S62, S72, S82, S92/
- Шилбэ болон тахилзуур ясны хугарал /S82/
- Мухар олгойтас /K35/
- Цөсний хүүдийтас /K81/
- Бөөрний аяганцар, тэвшинцрийн үрэвсэл /N10/
- Гуурсан хоолойн хөшүүн бус багтраа /J45/
- Уушгины архаг бөглөрөлт өвчин /J44/
- Уушгины гуурсан хоолойн үрэвсэл /J20-J21/
- Уушгины хатгалгаа /J10-J18/
- Цээжний өвдөлт (яс булчингийн гэмтэл, ходоод гэдэс, амьсгалын) /R07.1/
- Хоол боловсруулах замын цус алдалт (амин үйл тогтвортой) /K92.2
- Аяндаа зулбах /O03/
- Уналт, таталт /G40/
- Сэтгэц, зан үйлийн эмгэг /F00-F99/
- Сэтгэцийн өвчний цочмог хөдлөл-амиа хорлох сэдэлтэй /F31.4/
- Мигрень /G43-G43.9/
- Бөөрний чулууны өвдөлт /N20/
- Нуруу, нугасны гэмтэл (диск) /S33.0/
- Олон хэлбэрт шүүдэст улайрал, Стивенс-Джонсоны хамшинж L51
- Их талбайг хамарсан арьс, салстын бүтцийн өөрчлөлт - нийт биеийн гадаргуугийн 50-75%, цэврүү бол 30%-75% хамарсан /R23/
- Цэлцрүүт эмгэгүүд нийт биеийн гадаргуугийн 30 хувиас дээш хамарсан /L10-14/
- Стафиллококкт цэврүүт арьсны хамшинж (Риттерийн өвчин) – /L00 /
- Халууралт нейтрофилт дерматоз (Свитын хамшинж) /L98.2/

- Ангионеврозийн хаван /Т78.3/
- I-II зэргийн нийт биеийн гадаргуугийн 10-19% хамарсан түлэгдэл /Т31.1/
- Цээж хэвлийн ил шарх /амин үйл тогтвортой/ /S21, S31/

4.5. Эрэмбэ-IV. Яаралтай бус үйлчлүүлэгч

4.5.1. Эрэмбийн хэрэглээ: Аль нэгэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны эмгэг өөрчлөлттэй энэ нь даамжрах боломжтой, нэгээс хоёр цагийн дотор үнэлгээ хийж эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай эмгэгүүд хамаарна. Энэ эрэмбийн үйлчлүүлэгчдэд 60 минутаас хэтрэхгүй хугацаанд эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлнэ.

4.5.2. Энэ үйлчлүүлэгчийг **НОГООН** өнгөөр эрэмбэлэн тэмдэглэнэ.

4.5.3. Үйлчлүүлэгчийн гаднах харагдах байдал (мэдрэмжийн үнэлгээ)-д дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

- Хөнгөн зэргийн толгойн гэмтэл (Ухаантай, бөөлжилтгүй)
- Ухаан санаа самуурах (Архаг)
- Хэвлийн өвдөлт (цочмог)
- Бөөр шээсний замын халдвар (хүндрэлтэй болон шинж тэмдэгтэй)
- Чихний өвдөлт
- Амьсгаадах (Хөнгөн зэргийн амьсгалын гачаалт байдал)
- Цээжний тэвчиж болох өвдөлт, хөнгөн зэргийн гэмтэл эсвэл яс, булчингийн гэмтэл
- Гэдэсний түгжрэл (Шугаман үнэлгээгээр 4-өөс бага оноо)
- Бөөлжилт болон суулгалт (усгүйжилтийн шинжгүй)
- Сэтгэцийн хөнгөн өөрчлөлт бүхий айдасын болон сандрах хариу урвал, сульдлын хам шинж
- Сэтгэцийн хөнгөн өөрчлөлт бүхий ялимгүй зовлонт болон булчин татваганах байдал
- Архи болон сэтгэц идэвхит эм бодисын шартах болон хараат байдлын хам шинж
- Амиа хорлох сэдэл бүхий сэтгэл гутралтай
- Харшлын хөнгөн зэргийн урвалтай
- Арьсны загатнах зовиуртай
- Бага талбайг хамарсан арьс, салстын бүтцийн өөрчлөлт - нийт биеийн гадаргуугийн 25-50%, цэврүү бол 10-30% хамарсан арьсны тууралттай
- Нурууны архаг өвдөлт
- Өвдөлтийн 4-7 зэрэг

4.5.4. **НОГООН** эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна. Үүнд:

- Гавал тархины гэмтэл Глазго комын үнэлгээ 12-15, /S02-S05/
- Үе холбоос сунах, өнгөц гэмтэл /S00-S99/
- Дунд, гадна чихний үрэвсэл /H66.0/
- Зүрхний бус цээжний өвдөлт /R07.3/
- Ходоод улаан хоолойн сөргөө /K21/
- Амиа хорлох сэдэлтэй- сэтгэл гутралтай /F31.4/

- Чонон хөрвөс /L50/
- Хурц арьсны үрэвсэлтэй /L20-L30/
- Нүдний эвэрлэгт гадны биет орох /T15.0-T15.9/
- Нуруу нугасны гэмтэл /T09/, жийргэвчний суналт /S33.0/
- Амьсгалын дээд замын үрэвсэлтэй /J00-J06/
- Толгойн өвдөлт (мигреньгүй, архаг) /G44.0-G44.8/
- I-II зэргийн нийт биеийн гадаргуугийн 0-10% хамарсан түлэгдэл /T31.0/

4.6.Эрэмбэ-V. Хүлээгдэх боломжтой үйлчлүүлэгч

4.6.1. Эрэмбийн хэрэглээ: Энэ эрэмбэд цочмог боловч яаралтай тусламж шаардлагагүй эсвэл архаг өвчин үгдэрсэн, хүлээгдэх боломжтой эмгэгүүд хамаарна. Дээрх тохиолдолд үйлчлүүлэгчийг 120 минутаас хэтрэхгүй хугацаанд эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлнэ.

4.6.2. Энэ үйлчлүүлэгчийг **ЦАГААН** өнгөөр эрэмбэлэн тэмдэглэнэ.

4.6.3. Үйлчлүүлэгчийн гаднах харагдах байдал (мэдрэмжийн үнэлгээ)-д дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

- Хөнгөн зэргийн яаралтай тусламж шаардлагагүй гэмтэл
- Боолт солих (хүндрэл өгөөгүй шарх)
- Суулгалт (хөнгөн зэргийн эсвэл усгүйжилт үүсээгүй)
- Бөөлжилт-ухаан санааны байдал хэвийн тохиолдол (усгүйжилтгүй)
- Сарын тэмдгийн хямрал
- Хөнгөн зэргийн зовиур шаналгаанууд
- Хэвлийн архаг өвдөлт
- Өвдөлтийн зэрэг 4-өөс бага
- Сэтгэцийн хямралууд (сэтгэц органик болон нойргүйдлийн хам шинж)
- Сэтгэлийн хямралууд
- Эмийн эмчилгээ хийлгэх
- Эмчийн зөвлөгөө авах, утсаар зөвлөлгөө авах хүсэлт гаргасан тохиолдлууд

4.6.4. **ЦАГААН** эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна. Үүнд:

- Нурууны жийргэвчний цүлхийлт /S33.0/
- Амьсгалын дээд замын үрэвсэл /J00-J06/
- Ходоод гэдэсний хямрал /K30/
- Бөөлжилт /R11.10/
- Сарын тэмдгийн хямрал /N94/
- Өтгөн хаталт /K59/
- Ноцтой бус өнгөц зулгарал /T008/
- Урьдчилан сэргийлэх үзлэг /Z00/
- Арьсны тууралттай - Бага талбайг хамарсан зовиур багатай /нийт биеийн гадаргуугийн 25%, цэврүү бол 10 хувиас бага/
- Артерийн даралт нэмэгдсэн, толгой өвдсөн, бие тавгүйрсэн, даарч хөрсөн, хэт халууцсан, ханиалгасан, зогсуулсан, хүчтэй бус архаг өвдөлт илэрсэн, хоолны дуршил, шингэцийн алдагдал, толгой эргэсэн, түр муужирсан, зүрх дэлссэн, нүд, шүд, хамар, хоолой, мөчдийн өвдөлт, хөшилт, хүүхэд насны

онцлогт хамаарах болон хооллолт, дэглэм сахих, эрүүл амьдрах ёсны тухай эмчийн (ерөнхий) зөвлөгөө авах, утсаар зөвлөгөө авах.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
 12 сарын 30-ны өдрийн 8/14 дугаар
 тушаалын гуравдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭРЭМБЭЛЭЛТ

Эрэмбэ		Эрэмбийн тайлал	Эмнэлзүйн голлох байдал	Тусламж эхлэх хугацаа	Эрэмбэ тэмдэглэх өнгө
№	Ангилал				
I	Амь тэнссэн	Зүрх зогсох, амин чухал эрхтний үйл ажиллагаа зогсох аюул шууд заналхийлсэн эмгэгүүд	Зүрх зогсох Амьсгал зогсох Тархины үхэл хавсарсан томоохон гэмтлүүд шоктой	Шууд эхлэх	Хөх
II	Нэн яаралтай	Үйлчлүүлэгчийн амин үйл гүнзгий алдагдаж, нэн яаралтай тусламж үзүүлэхгүй бол амьсгал, зүрх зогсоход хүрсэн хүнд байдалтай өвчтөн Нийгэмд болон орчиндоо өөртөө аюултай үйлдэл үйлдэхүйц байдал	Хавсарсан гэмтэл, амьсгалын гачаалтай, Сэтгэцийн хувьд хурц өөрчлөлттэй	15 минут	Улаан
III	Яаралтай	Эмнэлзүйн байдлын улмаас явж чадахгүй болсон байдалтай, амин үйлийн үзүүлэлтүүд ноцтой өөрчлөгдсөн, тусламж хүлээхэд хүндрэлтэй, амбулаторийн нөхцөлд тусламж үзүүлэх боломжгүй, Нийгэм хамт олны дунд өөрийгөө авч явах чадвар болон шүүмжлэлт чанар буурсан	Амьсгал давчдсан, тахикардитай, артерийн даралт хэт буурсан эсвэл нэмэгдсэн, цээжээр хүчтэй өвдөх, бусад хэлбэрийн хүчтэй өвдөлт, нугасны болон мөчдийн хүнд гэмтэл, арьсны талбайг 50-75% хамарч гэмтээсэн салстын гэмтэл хавсарсан, Сэтгэцийн хувьд хурцавтар байдал	30 минут	Шар
IV	Яаралтай бус	Өвчтөн өөрөө явах боломжтой, амин үйлийн алдагдлын мэдэгдэхүйц өөрчлөлттэй, Сэтгэцийн тулгамдсан асуудалтай	Өвдөлт, халуурсан, ханиалгасан, толгойн хөнгөн гэмтэл, Сэтгэцийн хувьд хурц биш боловч хэвтүүлэн эмчлэх шаардлагатай	60 минут	Ногоон
V	Хүлээгдэх боломжтой	Цочмог бус явцтай илрэх (архаг) өвчнүүд, хуучин гэмтэл, бэртэл, Зонхилон тохиолдох сэтгэцийн өөрчлөлт	Нурууны өвдөлт (радикулит), чихрийн шижин хүндрэлгүй хэлбэр, холестеролын хэмжээ нэмэгдсэн байх, Хэвтүүлэн эмчлэх шаардлагагүй, зөвлөгөө өгч буцаах боломжтой	120 минут	Цагаан